



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2026/143/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Дорноговь аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Аудитын менежер:

Утас: 70523020

Ахлах аудитор:

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

У.Оюунтүлхүүр

Цахим хаяг: oyuntulkuur.u@audit.gov.mn

О.Нарангарав

Цахим хаяг: narangarav.o@audit.gov.mn

1.Аудитын санал дүгнэлт



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гуудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2026.02.09 № 1-6/М

танай _____ -ны № _____ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА, ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА
Ж.ДЭЛГЭРСАЙХАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 12.3 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлж, тус байгууллага нь үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай байсан шинжилгээний тоног төхөөрөмжийг худалдан авахад зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд тус байгууллага нь санхүүгийн тайланг бэлтгэх, нягтлан бодох бүртгэлийг хөтлөхдөө аккруэл суурийг бүрэн хөтлөөгүйгээс нийт 22.1 сая төгрөгийн бодит зардлын гүйцэтгэлийг тухай сард нь хүлээн зөвшөөрөөгүй, сарын мэдээний авлага, өглөгийг зөрүүтэй илэрхийлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

442505021

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	14,097,189.82	4,641,323.17
33	АВЛАГА	7,296,089.82	18,223.17
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	226,175.00	-
335	Бусад авлага	7,069,914.82	18,223.17
3351	Байгууллагаас авах авлага	7,069,914.82	18,223.17
35	БАРАА МАТЕРИАЛ	6,801,100.00	4,623,100.00
351	Түүхий эд материал	1,865,000.00	-
35130	Эм боох материал	1,865,000.00	-
354	Хангамжийн материал	4,936,100.00	4,623,100.00
35410	Бичиг хэргийн материал	-	40,000.00
35420	Аж ахуйн материал	4,236,100.00	4,583,100.00
35440	Түлш, шатах тослох материал	700,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	356,399,963.46	358,146,897.54
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	356,399,963.46	358,146,897.54
392	Биет хөрөнгө	313,263,963.46	315,010,897.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	56,561,820.00	56,561,820.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(6,075,887.04)	(7,088,534.88)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	199,861,352.95	199,861,352.95
39204	Хуримтлагдсан элэгдэл	(24,944,444.48)	(50,913,913.04)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	104,357,290.00	119,005,580.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(25,982,802.13)	(8,530,051.49)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,479,900.00	10,479,900.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(993,265.84)	(4,365,256.00)
393	Биет бус хөрөнгө	43,136,000.00	43,136,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	43,136,000.00	43,136,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	370,497,153.28	362,788,220.71
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	35,902.01	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	35,902.01	-
413	Өглөг	35,902.01	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	35,902.01	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	370,461,251.27	362,788,220.71
51	Засгийн газрын хувь оролцоо	370,461,251.27	362,788,220.71
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	80,638,053.00	80,638,053.00
51101	Өмч: - төрийн	80,638,053.00	80,638,053.00
512	Хуримтлагдсан үр дүн	283,982,596.81	276,309,566.25
51210	Өмнөх үеийн үр дүн	283,982,596.81	283,982,596.81
51220	Тайлант үеийн үр дүн	-	(7,673,030.56)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,840,601.46	5,840,601.46
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	370,497,153.28	362,788,220.71

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	847,064,542.95	797,601,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	201,173,842.95	17,597,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	201,173,842.95	17,597,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	50,165,200.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	50,165,200.00	-
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө	150,833,642.95	17,517,100.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа материал	175,000.00	80,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	645,890,700.00	780,004,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	645,890,700.00	767,812,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	645,890,700.00	767,812,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	12,192,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	12,192,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	652,933,342.27	805,274,830.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	652,933,342.27	805,274,830.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	585,569,586.77	728,466,580.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	464,783,207.25	585,322,873.22
210101	Үндсэн цалин	240,623,739.75	328,386,838.80
210102	Нэмэгдэл	142,809,387.50	158,077,334.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41,145,621.00	67,760,000.00
210104	Урамшуулал	40,204,459.00	31,098,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,755,893.98	19,462,043.76
210201	Тэтгэврийн даатгал	2,823,930.75	6,250,520.70
210202	Тэтгэмжийн даатгал	924,645.00	737,497.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	82,071.25	368,748.72
210204	Ажилгүйдлийн даатгал	82,070.25	368,748.78
210205	Эрүүл мэндийн даатгал	8,843,176.73	11,736,528.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,986,875.46	30,715,666.58
210301	Гэрэл, цахилгаан	1,545,664.46	2,326,789.58
210302	Түлш, халаалт	5,512,811.00	5,301,637.00
210303	Цэвэр, бохир ус	118,800.00	277,640.00
210304	Байрны түрээс	22,809,600.00	22,809,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,947,930.00	25,159,150.00
210401	Бичиг хэрэг	5,314,300.00	4,261,100.00
210402	Тээвэр, шатахуун	16,716,000.00	16,667,260.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	938,630.00	1,679,950.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	210,000.00	48,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,769,000.00	2,502,840.00
2105	Нормативт зардал	12,897,050.00	13,112,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,811,000.00	9,810,300.00
210502	Хоол, хүнс	2,997,850.00	3,302,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	88,200.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,371,910.00	7,748,880.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,475,500.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	126,000.00	250,000.00
210604	Урсгал засвар	8,770,410.00	7,498,880.00
2107	Томиллолт, зочны зардал	3,272,000.00	4,570,000.00
210702	Дотоод албан томиллолт	3,272,000.00	4,570,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,462,602.00	9,422,601.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	8,574,715.40
210803	Даатгалын үйлчилгээ	1,125,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	253,602.00	187,736.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	112,178.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	89,000.00
210807	Газрын төлбөр	7,000.00	86,272.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	372,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,092,118.08	32,952,565.92
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24,092,118.08	32,952,565.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,363,755.50	76,808,249.68

Дорноговь аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг	62,969,547.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	61,714,047.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,255,500.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,394,208.50	76,808,249.68
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,394,208.50	76,808,249.68
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	194,131,200.68	(7,673,030.56)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	194,131,200.68	(7,673,030.56)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	645,890,700.00	780,004,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	645,890,700.00	780,004,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	645,890,700.00	767,812,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	645,890,700.00	767,812,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	12,192,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	12,192,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	630,513,100.00	762,822,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	630,513,100.00	762,822,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	563,149,344.50	686,014,050.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	464,190,633.50	584,943,888.73
210101	Үндсэн цалин	240,011,100.00	309,964,183.40
210102	Нэмэгдэл	142,829,453.50	171,147,179.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41,145,621.00	69,827,300.00
210104	Урамшуулал	40,204,459.00	34,005,225.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,484,787.10	18,609,488.05
210201	Тэтгэврийн даатгал	2,594,033.25	5,407,067.22
210202	Тэтгэмжийн даатгал	304,027.50	733,974.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	82,071.25	374,487.29
210204	Ажилгүйдлийн даатгал	82,071.25	359,187.29
210205	Эрүүл мэндийн даатгал	10,422,583.85	11,734,771.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,754,731.90	24,668,810.14
210301	Гэрэл, цахилгаан	2,508,431.90	1,364,022.14
210302	Түлш, халаалт	7,841,100.00	2,973,348.00
210303	Цэвэр, бохир ус	118,800.00	277,640.00
210304	Байрны түрээс	22,286,400.00	20,053,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,444,030.00	24,931,350.00
210401	Бичиг хэрэг	4,999,400.00	3,955,100.00
210402	Тээвэр, шатахуун	16,496,000.00	15,949,460.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	938,630.00	1,679,950.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	210,000.00	48,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	800,000.00	3,298,840.00
2105	Нормативт зардал	13,495,650.00	11,147,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,999,200.00	7,545,300.00
210502	Хоол, хүнс	2,997,850.00	3,302,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	498,600.00	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,124,910.00	7,662,680.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,151,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	499,000.00	400,000.00
210604	Урсгал засвар	7,474,910.00	7,262,680.00
2107	Томилолт, зочны зардал	3,192,000.00	4,570,000.00
210702	Дотоод албан томилолт	3,192,000.00	4,570,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,462,602.00	9,480,033.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	975,000.00	8,611,147.40
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	209,786.00	187,736.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	112,178.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	89,000.00

Дорноговь аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210807	Газрын төлбөр	50,816.00	86,272.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	393,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,363,755.50	76,808,249.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	62,969,547.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	61,714,047.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,255,500.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,394,208.50	76,808,249.68
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,394,208.50	76,808,249.68
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	15,377,600.00	17,182,400.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	15,377,600.00	17,182,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,377,600.00	17,182,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	15,377,600.00	17,182,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,377,600.00	17,182,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(15,377,600.00)	(17,182,400.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөг/
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	80,638,053.00	5,843,962.48	89,890,791.75	176,372,807.23
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(39,395.62)	(39,395.62)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	80,638,053.00	5,843,962.48	89,851,396.13	176,333,411.61
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	194,131,200.68	194,131,200.68
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	80,638,053.00	5,840,601.46	283,982,596.81	370,461,251.27
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	80,638,053.00	5,840,601.46	283,982,596.81	370,461,251.27
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	80,638,053.00	5,840,601.46	283,982,596.81	370,461,251.27
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(7,673,030.56)	(7,673,030.56)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	80,638,053.00	5,840,601.46	276,309,566.25	362,788,220.71

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/				
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	804,107,000.00	691,004,050.32	113,102,949.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	804,107,000.00	691,004,050.32	113,102,949.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	797,285,200.00	691,004,050.32	106,281,149.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	663,778,800.00	584,943,888.73	78,834,911.27
210101	Үндсэн цалин	316,764,000.00	309,964,183.40	6,799,816.60
210102	Нэмэгдэл	220,299,600.00	171,147,179.55	49,152,420.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	84,480,000.00	69,827,300.00	14,652,700.00
210104	Урамшуулал	42,235,200.00	34,005,225.78	8,229,974.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,124,000.00	18,609,488.05	7,514,511.95
210201	Тэтгэврийн даатгал	9,070,000.00	5,407,067.22	3,662,932.78
210202	Тэтгэмжийн даатгал	1,067,000.00	733,974.58	333,025.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	533,000.00	374,487.29	158,512.71
210204	Ажилгүйдлийн даатгал	533,000.00	359,187.29	173,812.71
210205	Эрүүл мэндийн даатгал	14,921,000.00	11,734,771.67	3,186,228.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,695,400.00	24,668,810.14	2,026,589.86
210301	Гэрэл, цахилгаан	2,700,400.00	1,364,022.14	1,336,377.86
210302	Түлш, халаалт	4,404,800.00	2,973,348.00	1,431,452.00
210303	Цэвэр, бохир ус	374,400.00	277,640.00	96,760.00
210304	Байрны түрээс	19,215,800.00	20,053,800.00	(838,000.00)
2104	Хангамж, бараа материалын зардал	29,664,400.00	24,931,350.00	4,733,050.00
210401	Бичиг хэрэг	5,453,300.00	3,955,100.00	1,498,200.00
210402	Тээвэр, шатахуун	17,210,000.00	15,949,460.00	1,260,540.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,537,300.00	1,679,950.00	857,350.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	275,200.00	48,000.00	227,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,188,600.00	3,298,840.00	889,760.00
2105	Нормативт зардал	14,885,600.00	11,147,800.00	3,737,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,806,600.00	7,545,300.00	3,261,300.00
210502	Хоол, хүнс	3,480,600.00	3,302,500.00	178,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	598,400.00	300,000.00	298,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,968,800.00	12,652,680.00	1,316,120.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	4,990,000.00	10,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	598,400.00	400,000.00	198,400.00
210604	Урсгал засвар	8,370,400.00	7,262,680.00	1,107,720.00
2107	Томилолт, зочны зардал	7,481,700.00	4,570,000.00	2,911,700.00
210702	Дотоод албан томилолт	7,481,700.00	4,570,000.00	2,911,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,686,500.00	9,480,033.40	5,206,466.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,665,000.00	8,611,147.40	3,053,852.60
210803	Даатгалын үйлчилгээ	1,488,600.00	-	1,488,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	539,500.00	187,736.00	351,764.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	142,300.00	112,178.00	30,122.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	89,000.00	89,000.00	-
210807	Газрын төлбөр	164,600.00	86,272.00	78,328.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	597,500.00	393,700.00	203,800.00

Дорноговь аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,821,800.00	-	6,821,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,821,800.00	-	6,821,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,821,800.00	-	6,821,800.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	804,107,000.00	767,812,300.00	36,294,700.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	804,107,000.00	767,812,300.00	36,294,700.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	804,107,000.00	767,812,300.00	36,294,700.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	16	16	-
620001	Удирдах ажилтан	1	1	-
620002	Гүйцэтгэх ажилтан	15	15	-
620003	Үйлчлэх ажилтан	0	0	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

			/төгрөг/
Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,192,400.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,192,400.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,192,400.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,192,400.00	
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,192,400.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,192,400.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,192,400.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,192,400.00	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дорноговь аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахаар шилэн дансны мэдээлэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор О.Нарангарав гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер У.Оюунтүлхүүр, дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорноговь аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 28/33 дугаар, залруулсан санхүүгийн тайланг 2026 оны 02-р сарын 04-ны өдрийн 28/46 дугаар албан бичгээр тус тус ирүүлсэн байна.

3.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024.12.31-ний санхүүгийн тайлангийн нийт зардал 653.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 6.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор дээд шатны байгууллагаас өгсөн заавар, зөвлөгөөг мөрдөж ажилласан байна.

3.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

3.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны сайтад холбогдох журмын дагуу байршуулбал зохих 4,541.4 сая төгрөгийн 51 мэдээллийг байршуулснаас 475.0 сая төгрөгийн 8 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан мэдээлсэн байдлын хэрэгжилт 100 хувьтай, хугацаа хоцролтын хэрэгжилт 84.3 хувьтай байна.

3.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

3.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант оны эхний 9 сарын санхүүгийн тайлан, баримтад завсрын аудитыг хийн, санхүүгийн тайланг үнэн зөв тайлагнаагүй байх, Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн буюу тодруулга, тэмдэглэл бэлтгээгүй байх, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, бүрэн хөтлөөгүй байх, цалингийн зардлыг санхүүгийн тайланд зөрүүтэй тусгасан, цалингаас суутгасан суутгалыг харилцагч байгууллагад зөрүүтэй шилжүүлсэн, урьдчилгаа болон гарт олгосон цалин хөлсийг зөрүүтэй шилжүүлсэн байх, зардлын эдийн засгийн ангиллыг буруу зарцуулах төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй байх зэрэг 6 горим сорилыг хэрэгжүүлж төлөвлөгөө хөтөлбөрийг батлуулсан.

Завсрын аудитаар нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой 16.6 сая төгрөгийн алдааг залруулан, санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг болох нэмэлт тодруулга, тэмдэглэл тайлан бэлтгэх зөвлөмжийг хүргүүлсэн.

3.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн аудитын шийдвэрүүдийг байхгүй

Хүснэгт 3: Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	0	-	0	-	0%
Албан шаардлага	0	-	0	-	0%
Зөвлөмж	0	-	0	-	0%
Нийт дүн	0	-	0	-	0%

3.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татсан асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 26.5 сая төгрөгийн 6 алдаа, зөрчил илэрснээс, аудитын явцад 20.2 сая төгрөгийн 3 алдааг залруулж, залруулагдаагүй 6.3 сая төгрөгийн 3 зөрчилд 0.9 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 5.4 сая төгрөгийн 2 зөвлөмж өгөв.

4.1 Аудитын явцад залруулсан алдаа:

1. Байр ашиглалттай холбоотой авлагын үлдэгдэл 10,588.8 мянган төгрөгийг зардлын бодит гүйцэтгэлд бүртгэн тайлагнахдаа тухайн сард нь бус улиралд эсвэл дараа сард нь, сарын цалингийн бодит гүйцэтгэлийг зөрүүтэй бүртгэн цалингийн зардлыг 2,254.4 мянган төгрөгөөр бууруулах бичилт хийж тайланг тааруулан, амралтын цалингийн урьдчилгааг тухай бүр бүртгээгүйгээс 3,807.8 мянган төгрөгийг тайлагнаагүй алдааг завсрын аудитаар залруулан бүртгэсэн.

2. Түлш халаалт, цэвэр бохир усны бодит зардлын гүйцэтгэлийг 308.9 мянган төгрөгөөр, бичиг хэрэг шуудан холбооны зардлын бодит гүйцэтгэлийг 148.5 мянган төгрөгөөр, шуудан холбоо хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардлыг 25.0 мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланд цалин, ажил олгогчийн НДШ-ийн зарлагыг төсвийн гүйцэтгэлийн тайлангаас 520.6 мянган төгрөгөөр тус тус зөрүүлэн тайлагнасан байна.

3. Цалингийн зардлыг мөнгөн гүйлгээний тайланд 520.6 мянган төгрөгөөр, үр дүнгийн тайланд 662.1 мянган төгрөгөөр, ажил олгогчийн НДШ-ийн зарлагыг мөнгөн гүйлгээний тайланд 520.6 мянган төгрөгөөр, үр дүнгийн тайланд 870.2 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй бүртгэн тайлагнасан.

4.2 Албан шаардлага

1. Цалин хөлс нэмэгдэл урамшил болон бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас АО-ийн НДШ-ийн зардалд нийт 906.7 мянган төгрөгийг шилжүүлэн төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Тодруулгатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн буюу тодруулга, тэмдэглэл бэлтгэж гаргаагүй байгаа нь санхүүгийн тайлан иж бүрэн илэрхийлэгдэхгүй байх, санхүүгийн тайлан дахь мэдээлэл бүрхэг тодорхой бус болох, холбогдох стандарт, хууль, журам зөрчигдөх эрсдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна: 8.1.5.санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан заавар, журамтай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлангийн тодруулга, тэмдэглэлийг гаргаж санхүүгийн тайланг иж бүрэн, үнэн зөв тайлагнаж байх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэн жилийн эцсийн санхүүгийн тайланд нэмэлт тодруулга тайланг хавсаргаж ирүүлсэн байна.

2. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой

Илрүүлэлт: Жилийн эцсийн аудитын гүйцэтгэлээр санхүүгийн тайланг бэлтгэх, нягтлан бодох бүртгэлийг хөтлөхдөө 5,409.3 мянган төгрөгийн гүйлгээг аккруэл сууриар бүртгэлгүй, зардлын бодит гүйцэтгэлийг тухай сард нь бус ажил гүйлгээний төлбөрийг шилжүүлж байгаа сард хүлээн зөвшөөрч бүртгэж, завсрын аудитаар залруулан бүртгэсэн алдааг давтан гарган байна. Уг зөрчил нь тухайн сарын авлага, өр төлбөрийг зөрүүтэй мэдээлэх нөхцөл болж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, 26.2 “Төсвийн бүртгэлийг тохируулсан аккрузл сууриар бүртгэж, тайлагнана”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө” гэсэн заалтууд, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” зэрэгтэй тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг бэлтгэн гаргах, нягтлан бодох бүртгэл хөтлөхдөө холбогдох хууль, тогтоомж, үндэсний стандартын дагуу аккрузл сууриар хөтлөн, авлаг, өр төлбөрийг үнэн зөвөөр илэрхийлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
НББ-ийг аккруэл сууриар бүртгээгүй	1	16,651.5	-	-	1	16,651.5	1	16,651.5	-	-	-	-
Бодит зардлын гүйцэтгэлийг зөрүүтэй тайлагнасан	1	1,002.9			1	1,002.9	1	1,002.9				
Цалин, АО-НДШ зардлын гүйцэтгэлийг алдаатай тайлагнасан	1	2,573.5	-	-	1	2,573.5	1	2,573.5	-	-	-	-
Дүн	3	20,227.9	-	-	3	20,227.9	3	20,227.9	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зардлыг зориулалт бусаар зарцуулсан	1	906.7	-	-	1	906.7	-	-	-	-
Нэмэлт тодруулга, тэмдэглэл тайлан бэлтгээгүй	1	-	-	-	-	-	1	-	-	-
Зардлын гүйцэтгэлийг аккруэл сууриар бүртгэн тайлагнаагүй байна.	1	5,409.3	-	-	-	-	1	5,409.3	-	-
Дүн	3	6,316.0	-	-	1	906.7	2	5,409.4	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-